



**ӨГИЙНУУР СУМЫН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН
ЗАХИРАГЧИЙН 2016 ОНЫ ЖИЛИЙН ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛ, САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН**

**Аудитын код: АРА-
2017/11/СТА-ТТЗ**

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

ТАБ-ын Тэргүүлэх аудитор
Утас: 70333141
Цахим хаяг:

Аудитын менежер:
Утас: 70332860
Цахим хаяг:

ТАБ-ын хаяг: Архангай
аймгийн Аудитын газар
Байршил: Эрдэнэбулган сум
Цахим хуудас:
www.audit.mn

Аудитын тайлан

- Хавсралт 1: Аудитын гэрчилгээ
- Хавсралт 2: Аудитын тайлан
- Хавсралт 3: Менежмент захидал
- Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн
тайлан, төсвийн гүйцэтгэл

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	3
2.1	Оршил	3
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	3
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	4
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	7
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11	Шилэн дансны мэдээлэл	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Менежментийн захидал	10
3.1	Орлого	11

1 Аудитын гэрчилгээ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

ӨГИЙНУУР СУМЫН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ Л.АЛТАНГЭРЭЛ ТАНД ТАНИЛЦУУЛЖ БАЙНА.

Энэхүү тайландаа үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Өгийнуур сумын ТЕЗ-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлгээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Өгийнуур сумын ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017.03.07 - наас 2017.03.25 – ны хооронд хийж, аудитын тайланг эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Ахлах шинжээч Н.Энхчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Өгийнуур сумын ТЕЗ 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа төрийн аудитын байгууллагад 2017.03.07-ны өдөр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Өгийнуур сумын ТЕЗ Монгол улсын ЗЗНДТУТХуулийн 18.1 дэх хэсэгт “Сум, дүүргийн Хурал нь Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, яам, агентлаг, дээд шатны Хуралд болон төрийн эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтанд хуулиар харьяалуулснаас бусад тухайн нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн болон зохион байгуулалтын ямар ч асуудлыг хэлэлцэж бие даан шийдвэрлэх эрхтэй бөгөөд өөрийн эрхлэх хүрээний асуудлыг онцгой бүрэн эрхэд хадгалж хэрэгжүүлнэ” гэсэн эрхэм зорилгын дор Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд дараах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.Үүнд:

Өгийнуур сумын ТЕЗ дээрх хуулиар тогтоосон чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд өөрийн эрхэлэх асуудал, үйл ажиллагааныхаа чиглэл, цар хүрээг дараах байдлаар тодорхойлж баталгаажуулжээ. Үүнд:

Тайлант хугацаанд Өгийнуур сумын ТЕЗ “Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, иргэд хүнд сурталгүй аливаа чирэгдэлгүй, хурдан шуурхай үйлчлэх явдлыг хэвшүүлж, эдийн засаг нийгмийн бусад хөтөлбөрүүдтэй нягт уялдсан цэгцтэй, уян хатан бөгөөд үр ашигтай үйлчилгээг бий болгоно.” гэсэн зорилт дэвшүүлэн ажиллажээ.

Өгийнуур сумын Засаг дарга-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Өгийнуур сумын Засаг дарга-Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, иргэд хүнд сурталгүй аливаа чирэгдэлгүй, хурдан шуурхай үйлчлэх явдлыг хэвшүүлж, эдийн засаг нийгмийн бусад хөтөлбөрүүдтэй нягт уялдсан цэгтэй, уян хатан бөгөөд үр ашигтай үйлчилгээг бий болгоно.” гэсэн зорилт дэвшүүлэн ажиллажээ.

Өгийнуур сумын Засаг дарга төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Няглан бodoх бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, няглан бodoх бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Няглан бodoх бүртгэлийн тухай, Монгол Улсын Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын няглан бodoх бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388, 2008 оны 352 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх няглан бodoх бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаалаар баталсан Төсвийн орлогын эдийн засгийн дэлгэрэнгүй ангилал, Төсвийн зарлагын эдийн засгийн дэлгэрэнгүй ангилал, төсвийн эх үүсвэрийн ангилал, Төсвийн бусад мэдээллийн болон Балансын дансны ангилал, “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” 2014 оны 55 дугаар тушаалаар Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглахаар заавар, “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан “Төсвийн орлогын эдийн засгийн ангилал, Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал, Төсвийн зарлагын хөтөлбөрийн ангилал, Зардлын зориулалт, арга хэмжээний ангилал”, “Журам шинэчлэн батлах тухай” 2015 оны “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ыг 1 дүгээр хавсралт, “Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгын маягт”-ыг 2 дугаар хавсралтыг 341 дүгээр тушаалаар батлан тус бүр мөрдөн ашиглаж байна.

Түүнчлэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогтой холбоотой холбогдох бусад хууль тогтоомжууд, тэдгээрийн хэрэгжилтийг хангуулахаар гаргасан Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаалаар баталсан дүрэм, журам, заавар, аргачлалыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

2.5 Няглан бodoх бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайландаа материаллаг алдаа байхгүй гэдгийг няглах үүднээс үйлчлүүлэгчийн няглан бodoх бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Өгийнуур сумын ТЕЗ төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 2 буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Өгийнуур сумын ТЕЗ санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “plastic” программ хангамж ашиглажээ.

2.6 ТӨЛӨВЛӨЛТИЙН ШАТАНД ТОДОРХОЙЛСОН ЭРСДЭЛ, ТҮҮНИЙГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өгийнуур сумын ТЕЗ-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуульяа.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 15 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.5 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 2 асуудал эрсдэл дунд үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 6 буюу “бага” байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт зардлын дүнгээс материаллаг түвшинг сонгон авсан шалтгаан нь тухайн байгууллагын тайлант хугацааны үйл ажиллагааг төлөөлж чадахуйц суурь үзүүлэлт гэж үзлээ.

Өгийнуур сумын ТЕЗ –ийн 2016 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2099,9 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь 22.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 2 чиглэлээр 2 эрсдэлтэй асуудалд 2 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 100 хувь буюу 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Сая төгрөгөөр)

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	2	128.5	
	Дүн	2	128.5	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Аудитаар сумын орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийн талаар дараах зөрчил илэрлээ.

- Өгийнүүр сумын ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 05 тоот тогтоолоор төсвийн орлогын төлөвлөгөөг 42.0 сая төгрөгөөр төлөвлөж 35.8 сая төгрөгөөр төвлөрч 7 нэр төрлийн орлого 0.07- 1.2 сая төгрөгөөр тасарч, 4 нэр төрлийн орлого 0.02-0.9 сая төгрөгөөр давсан ч нийт орлогын төлөвлөгөө **6.2** сая төгрөгөөр тасарсан нь орлогын төлөвлөлт оновчгүй, шахуу төлөвлөхгүй байгаатай холбоотой байна.

Шийдвэрлэсэн нь: Сумын ИТХ-ын тогтоолоор батлагдсан орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийг хангулж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх

- Мөн Сум хөгжүүлэх сангийн орлогыг **205.5** сая төгрөгөөр баталсан бөгөөд гүйцэтгэлээр **14.7** сая төгрөг төвлөрч орлогын төлөвлөгөөг **122.3** сая төгрөгөөр тасалсан байна.

.Шийдвэрлэсэн нь: Сум хөгжүүлэх сангаас иргэдэд олгосон зээлийн эргэн төлөлтөнд онцгой анхаарч холбогдох арга хэмжээг авч, орлогын төлөвлөгөөг оновчтой төлөвлөж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Өгийнуур сумын Засаг дарга өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 1536348600 төгрөг хөрөнгийн зардалд 81280300 төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/Сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1754.8	1612.6	91.9%	142.0
1.1	Урсгал зардал	1536.3	1551.7	99.0%	14.7
1.2	Хөрөнгийн зардал /ОНХС/	81.3	76.3	93.9%	5.0
1.3	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл/ СХС/	137.0	14.7	10.7%	122.3

Тайлант оны төсвийн гүйцэтгэл **91.9** хувьтай байна. Төлөвлөгөө гүйцэтгэлийн зөрүү **142.0** сая төгрөг байна. Энэ үлдэгдэл нь орон нутгийн хөгжлийн сангийн үлдэгдэл **5.0** сая төгрөг, сум хөгжүүлэх сангийн эргэн төлөгдөх зээлийн дутуу санхүүжигдсэн **122.3** сая төгрөг, төсөвт байгууллагуудын хэмнэгдсэн үлдэгдэл буюу төвлөрүүлэх шилжүүлэг **14.7** сая төгрөг тус тус байна.

- Өгийнуур сумын ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 05 тоот тогтоолоор төсвийн орлогын төлөвлөгөөг 42.0 сая төгрөгөөр төлөвлөж 35.8 сая төгрөгөөр төвлөрч 7 нэр төрлийн орлого 0.07- 1.2 сая төгрөгөөр тасарч, 4 нэр төрлийн орлого 0.02-0.9 сая төгрөгөөр давсан ч нийт орлогын төлөвлөгөө 6.2 сая төгрөгөөр тасарсан нь орлогын төлөвлөлт оновчгүй, шахуу төлөвлөхгүй байгаатай холбоотой байна.

Мөн Сум хөгжүүлэх сангийн орлогыг **205.5** сая төгрөгөөр баталсан бөгөөд гүйцэтгэлээр **14.7** сая төгрөг төвлөрч орлогын төлөвлөгөөг **122.3** сая төгрөгөөр тасалсан байна.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийт **22.0** сая төгрөг зарцуулсан байна.

Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Өгийнуур сумын Засаг дарга Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

- Өмнөх онд 4-н нэр төрлийн орлого 0.2-1.2 сая төгрөгөөр тасарч орлогыг нэр төр бүрээр нь жигд ханган биелүүлэх талаар зөвлөмж хүргүүлсэн байна. Энэ оны орлогын төлөвлгөө мөн 7 нэр төрлөөр 0.07-1.9 сая төгрөгөөр тасарсан нь өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлэж ажиллаагүйтэй холбоотой байна.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Өгийнуур сумын ТЕЗ-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайландауд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Өгийнуур сумын ТЕЗ-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “**Зөрчилгүй**” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.9-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг бус, материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидалыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидалын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Өгийнуур сумын ТЕЗ-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг дансдаар үзүүлэв.

3.1 Орлого

Илрүүлэлт

➤ Өгийнүүр сумын ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 05 тоот тогтоолоор төсвийн орлогын төлөвлөгөөг 42.0 сая төгрөгөөр төлөвлөж 35.8 сая төгрөгөөр төвлөрч 7 нэр төрлийн орлого 0.07- 1.2 сая төгрөгөөр тасарч, 4 нэр төрлийн орлого 0.02-0.9 сая төгрөгөөр давсан ч нийт орлогын төлөвлөгөө 6.2 сая төгрөгөөр тасарсан нь орлогын төлөвлөлт оновчгүй, шахуу төлөвлөхгүй байгаатай холбоотой байна.

Мөн Сум хөгжүүлэх сангийн орлогыг **205.5** сая төгрөгөөр баталсан бөгөөд гүйцэтгэлээр **14.7** сая төгрөг төвлөрч орлогын төлөвлөгөөг **122.3** сая төгрөгөөр тасалсан байна.

Ахлах шинжээч.....Н.Энхчимэг

Эрсдэл

- Сумын ИТХ-аар баталсан Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө орлогын нэр төрлөөр биелэгдээгүйгээс санхүүжилтийн эх үүсвэр дутагдах эрсдэлтэй байх
- Орон нутгийн Төсвийн Төвлөрүүлэн захирагчийн үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүрэг биелэгдэхгүй байх

Зөвлөмж

- Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг орлогын нэр төрлөөр жигд хангулж ажиллах
- Орлого тасарч, давж байгаа шалтгааныг орлогын нэр төрөл бүр дээр судлан, төлөвлөлтийг оновчтой болгох
- Төсвийн тухай хуулийн 41.2.1 “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах
- Сум хөгжүүлэх сангаас иргэдэд олгосон зээлийн эргэн төлөлтөнд онцгой анхаарч холбогдох арга хэмжээг авч ажиллах

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийн биелэлтийг 2017.06.15-ны дотор албан тоотоор манайд ирүүлнэ үү.

